


**НҮБ-ын ХАС-тай ЭМХТ-ийн хамтарч хэрэгжүүлсэн “Шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 2019 онд хийсэн ажлын тайлан**

№	<i>Хөтөлбөр/төслийн агуулга</i>	<i>Гүйцэтгэл</i>
1	<p><i>Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар</i></p> <p>Монгол Улсад эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээг сайжруулах</p> <p>B6230 2017.04.10</p>	<p><i>Төсөл, хөтөлбөрийн зорилго</i></p> <p>Люксембургийн Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сангийн санхүүжилтээр Монгол Улсад эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээг сайжруулах.</p>
2	<p><i>Санхүүжилтийн эх үүсвэр</i></p> <p>Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сан</p>	<p><i>Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж</i></p> <p>Буцалтгүй тусламж</p>
3	<p><i>Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/</i></p> <p>Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан /3 жил 2019.09 хүртэл/</p>	<p><i>Үндсэн хэрэгжүүлэх байгууллага</i></p> <p>ЭМХТ, ЭХЭМҮТ, АШУҮИС</p>
4	<p><i>Төсөл хөтөлбөрийн зорилтууд</i></p>	<p><i>Зорилт 1.</i></p> <p>Ухаалаг утасны M-Health аппликэйшны агуулгыг боловсруулж, хөгжүүлэх</p> <p><i>Зорилт 2.</i></p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд зориулсан тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх</p>

5	<i>Төсөл хөтөлбөрийн зорилт:</i>	<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ</i>
	<p><i>1-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Ухаалаг утасны M-Health аппликэйшны агуулгыг боловсруулж, хөгжүүлэх</p>	<p><i>1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл</i></p> <p><i>Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эмчийн гарын авлага, эх, нярайд зориулсан веб хуудас, мобайл аппликэйшн программ хангамж хөгжүүлэх” ажлыг Тауэр Софт компанитай хамтран хийж гүйцэтгэн 2019 оны 4 дүгээр сард НҮБХАС-нд эх код болон ажиллах заавар журмын хамт хүлээлгэн өгсөн. Мөн тус аппликэйшныг ЭХЭМҮТ-д хүлээлгэн өгсөн бөгөөд цаашид ЭХЭМҮТ авч явах юм.</i></p> <p><i>Энэхүү ухаалаг утсанд суурилагдсан программын ашиглах заавар, хэрэглээний талаарх сургалтыг контент хөгжүүлэгч байгууллага АШУҮИС болон ЭХЭМҮТ бэлэн болгосны дараагаар Төв, Дархан-уул аймаг, Баянзүрх, СонгиноХайрхан дүүргийн эмч нарт хийхээр төлөвлөсөн.</i></p> 
	<p><i>2-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд зориулсан тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх</p>	<p><i>2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл</i></p> <p><i>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд зориулсан багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалтын тендерийг 2018 оны 12 сард зарлаж, тендерээр шалгарсан “Интерсайнс” ХХК болон “Биомед трейд” ХХК-тай 2019.06.28-ны өдөр №115, №116 дугаар гэрээг байгуулсан.</i></p>

**Эрүүл мэндийн сайдын 2019.09.06-ны өдрийн А/409 дүгээр тушаалын дагуу тус гэрээгээр нийлүүлэгдсэн 11 нэр төрлийн 140 ширхэг 179,723,400 төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг 27 эрүүл мэндийн байгууллагад 2019.09.17-ны өдөр гардуулан хүлээлгэж өгсөн.**



